

ҮХААГ-ЫН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧДЫН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНД ХЯНАЛТ,
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН
/2015 оны жилийн эцэс/

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд ХШҮ хийхдээ Монгол улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын хавсралт “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоол “Төсвийн шууд захирагч, Менежер, Төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг тус тус баримталж явцын үнэлгээг хийлээ.

Журмын 5.2.-т Төрийн жинхэнэ албан хаагч гэрээнийхээ хэрэгжилтийн явц байдлыг менежерт улирал тутам албан ёсоор мэдээлэх ба талууд явц байдлыг хэлэлцэж, холбогдох арга хэмжээ авч ажиллана. Байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж (албан хаагч) төрийн жинхэнэ албан хаагчийн гэрээний биелэлтийн явц байдалд хагас жил тутам хяналт-шинжилгээ хийнэ.

Мэргэжилтнүүдийн үнэлгээг хийхдээ хэлтсийн даргын саналыг харгалзаж дундажлаж тооцсон болно. ХШҮ багийн гишүүд өөрсдийн Үр дүнгийн гэрээний үнэлгээг тойргийн зарчмаар зохион байгуулж үнэлгээ хийлээ.

Оноог журмын үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх аргачлал хэсгийн 4.1 дэх заалт дагуу үнэллээ.

Тусгай арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-40 оноо, тусгайгаас бусад арга хэмжээг 0-30 оноо

Тухайн арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрсэн бол **30, 40**

тухайн арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч гүйцэтгэлийн зарим шалгуур үзүүлэлтийг хангаагүй, үр дүнд бүрэн хүрээгүй бол **20-29, 29-39**

тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн дуусаж, ажил хийгдэж байгаа бол энэ ажлын түвшинг харгалзан **14-19, 18-28**

тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн бол энэ ажлын түвшинг харгалзан **5-13, 7-17**

тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил хийгдэж эхэлсэн бол энэ ажлын түвшинг харгалзан **1-4, 1-6** оноо өгч,

тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ямар нэг ажил хийгдээгүй бол оноо (“0” гэж тэмдэглэнэ) өгөхгүй.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Төрийн албан хаагчийн “Үр дүнгийн гэрээ”-ний хэрэгжилт	Биелсэн 100 хувь		111	11100	
	Хэрэгжих шатандаа				
	үүний дотор	90 % /80.0-100%/	37	3449.2	
		70 % /60.0-80%/	1	66.7	
		50 % /40.0-60%/	8	424.3	
30 % /20.0-40%/		3	120		
	10 % /0.0-20%/				
Төрийн албан хаагчийн тоо- 7	Хугацаа болоогүй				
	Тасарсан	Зохион байгуулалтаас			
		Хөрөнгийн эх үүсвэрээс			
	Ноогдох оноо		47.35	94.7	

Дундаж **94.7** хувьтай байна.

Дөрөв. Дүгнэлт

- ✚ Нийт 11 заалт 30-50 хувийн хэрэгжилттэй гарсан. Эдгээр заалтад явцын үнэлгээ учир технологийн хугацаа болоогүй заалтууд орсон болно.
- ✚ Үр дүнгийн гэрээний төлөвлөлт доороосоо хийгдэж байгаа нь дунд болон урт хугацааны бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажил үйлчилгээ нийт албан хаагчдийн үр дүнгийн гэрээнд бага туссан байна. Нөгөө талдаа энэ нь үр дүнгийн гэрээний үнэлгээ харьцангуй өндрөөр үнэлэгдэх нөхцөл болж байна.
- ✚ Үр дүнгийн гэрээний заалтуудад тоон болон чанарын үзүүлэлтүүд, хүрэх түвшинг оновчтой тодорхойлж чадаагүйгээс гэрээ дүгнэхэд хүндрэл үүсч байна.
- ✚ Мал аж ахуйн хэлтсийн 2 мэргэжилтний үр дүнгийн гэрээний дийлэнх заалт Хэлтсийнхээ даргын гэрээний заалттай давхардсан утгатай байгаа байдлыг цаашид өөрчилж зөвхөн хариуцсан салбарын ажлуудыг гэрээнд тусгаж ажиллах, эсвэл журмын дагуу багийн гэрээ байгуулах тал дээр анхаарах шаардлагатай .
- ✚ Нийт төрийн захиргааны албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолыг бүрэн судлах.

Тав. Зөвлөмж

Төлөвлөлтөд анхаарах:

- Үр дүнгийн гэрээг төлөвлөхдөө урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд уялдуулж төлөвлөх, түүнийг нь шат шатны дарга нар танилцаж, чиглэл өгөх /журмын дагуу/. Өөрөөр хэлбэл Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлтийг **дунд хугацааны төлөвлөгөө** → **тухайн жилийн төлөвлөгөө** → **үр дүнгийн гэрээ** шатлалаар хийх, *пирамид зарчмыг*

баримтлах. Цаашид Газрын зүгээс эдгээр олон төлөвлөгөөг уялдуулж багтаасан ҮХАА-н салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулах шаардлага байна.

- ХШҮ-ээр хангалтгүй гарсан заалтуудыг менежерүүд үр дүнгийн гэрээнд тусгаж, эрчимжүүлэх шаардлагатай.
- Шалгуур үзүүлэлтүүд, хэрэгжүүлэх хугацааг тавихдаа тодорхой бичих. Жил, улирлаар биш сараар тавих.
- Үр дүнгийн гэрээнүүдийг нэг загварт оруулах./ Жишээ нь: Дарга нарын нэр, огноо, гарын үсэг байдаггүй, бичгийн цаасны хөдлөн байрлалд оруулж тайлагнах, илүү тэмдэглэл хийхгүй байх, МЕНЕЖЕР-ТШЗ-ын гэрээ, тайлагналтын загварыг ашиглах, ХШҮ-ний багийн даргын гарын үсгийг оруулах./
- АНЭЗЗорилтыг хангаж ажиллах гэсэн заалтыг О.Нэмэхбат даргаас бусад албан хаагчдын гэрээнээс хасч тооцох.
- Хэлтсийн дарга нар үр дүнгийн гэрээн дээр хэлтийн даргын ажил үүргийг тусгах./Мэргэжилтний ажил хангалтгүй байгаа тохиолдолд тухайн менежерийн үнэлгээ буурах зарчим мөрдөгдөх үндэс болно./
- Зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо “дутаахгүй, илүүдэхгүй” байх зарчмыг баримтлах.

Тайлагналт:

- Хэрэгжилтийг тайлагнахдаа тоон болон чанарын үзүүлэлтүүдийг суурь болон зорилтот түвшинтэй нь харьцуулж, шалгуур үзүүлэлтэй нийцүүлж, аль болох товч тайлагнах шаардлагатай. Заримт заалт, тайлагналт хэт ерөнхий байгаагаас дүгнэхэд хүндрэл үүсч үр дүнг тооцох боломжгүй байна.
- Ижил заалтуудад тоон мэдээллүүд зөрсөн цаашид анхаарах.
- Аймгийн Засаг даргын 2013 оны 01 албан даалгаврын хэрэгжилтийн хангах чиглэлээр мэргэжилтэн бүр идэвх санаачлага гаргаж ажиллах.
- Цаашид үнэлгээ хийхдээ ХШҮ, Хэлтсийн дарга, Газрын дарга /ХШҮ, Газрын дарга/ гэсэн дарааллаар журмын дагуу хийгдэнэ.

- Жишээ нь:

Үр дагавар	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн Түвшин	Үнэлгээ
Тарилгад хамрагдах малын тоо толгой өссөн байна.	Нийт тарилга хамрагдсан малын нийт сүрэгт эзлэх хувь.	2014 оны байдлаар нийт малын 11 хувьд тарилга хийсэн	2015 эхэн гэхэд нийт малыг 80 хувь хамруулна.	Нийт малыг 60 хувийг хамрууллаа.	70 Хувь

Төлөвлөлт, үр дүнгийн пирамид



ХШҮ-ний тайланг нэгтгэсэн: ХШҮ-ний ажлын хэсгийн дарга/Бат-Эрдэнэ/

ЗАСГИЙН ГАЗРЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨН ДЭХ ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ
ХАМААРАХ ЗОРИЛТЫН 2014 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоон үр дүнг үнэлэх, зөвлөмж дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан зорилго, арга хэмжээнүүдннн хэрэгжилтннн явцад хянапт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор багалсан "Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-ыг удирдлага болгов.

Хянапт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн 2014 оны эхний хагас жилийн тайланг судлах, 2012 оны статистикийн эмхэтгэл, 2012 оны 12 дугаар сарын статистикийн бюллетень, гадаад худалдааны барааны статистик мэдээ болон тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох газруудаас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв. Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах үр дүнг ерөнхий байдлаар урьдчилан тогтоогоод үнэлгээ хийх үед гарсан бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Дөрөв. Дүгнэлт

Тав. Зөвлөмж

Зургаа. Санал

МОНГОЛУЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗОРИЛТУУДЫШ 2014 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

№	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	Арга хэмжээний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, Үр дүнгийн үзүүлэлт	Гарсан үр дүн	ХШҮ
1	57. Дархан хотын Төмөрлөгийн	1	1. Дарханы Төмөрлөгийн	2013	Жилд 165.0 мянган тонн ган цувимал	Дархан Төмөрлөгийн үйлдвэр ТӨХК- нь төмөр толгойн орд газрыг ашиглан	80

	үйлдвэрийг шинэчилж хүдэр баяжуулдаг болох.		үйлдвэрт технологийн шинэчлэл хийж, хүдэр баяжуулдаг болно.			төмрийн хүдрээ нойтон баяжуулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлж, үйлдвэрийн барилгын ажил, техник тоног төхөөрөмжийг суурилуулах ажил 80 хувьтай хийгдэж байна. Ирэх оны 7 сард ашиглалтанд оруулахаар зорилт тавин ажиллаж байна.	
2	62.Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, цемент, төмөр хийц, шил, дулаалгын материал зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтлах.	2	4.Дархан-Уул аймагт арматур, төмөр хийцийн үйлдвэр байгуулна.	2013-2015	Үйлдвэр байгуулагдсан байна.	Тус үйлдвэрийг байгуулах хөрөнгө санхүүгийн эх үүсвэр болох жижиг дунд үйлдвэрийг дэмжих зээлийн санхүүжилтийн асуудал нээгдэж байгаа тул хоёр дахь хагас жилийн хугацаанд хэрэгжиж эхэлнэ.	10
		3	6.Дулаан тусгаарлах материалын үйлдвэрлэлийг дэмжих, хөнгөн дүүргэгч, хөнгөн бетон, эрдэс хөвөн, хонины ноосон дулаалгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг 100 хувь хангана.	2013-2016	Дотоодын хэрэгцээг 100 хувь хангадаг болсон байна.	Аймгийн хэмжээнд барилгын материалын цогцолбор байгуулах чиглэлээр Дархан Үйлдвэр технологийн парк нь Үндэсний сургалт зөвлөгөөнийг аймагтаа зохион байгуулж, барилгын томоохон компаниудыг урилгаар оролцууллаа. Дархан Үйлдвэр технологийн паркын 1-р бүсэд 11.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эко ноос ХХК хонины ноосоор дулаалгын материал үйлдвэрлэх үйлдвэрийг 8 сард ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Мөн Европын холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Чехийн ОУТББайгуулагын (People in Need) “Хонины ноосоор барилгын дулаалгын материал хийж, ашиглах хангамжийн сүлжээг бэхжүүлэх” төсөлтэй хамтран “Хонины ноос бэлтгэл” сэдэвт сургалтыг зохион байгуулан тус аймгийн 4 сумын 7 хоршооны 50 гаруй малчин хамрууллаа.	30
3	70. Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотын гадна байгаль орчинд ээлтэй, хаягдлаа бүрэн боловсруулах чадвартай арьс шир боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжих	4	1.Улаанбаатар, Дархан хотын гадна талд арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барьж эхэлнэ.	2012-2014	Дэд бүтцийг барьж эхэлсэн байна.	Засгийн газрын 2013 оны 249 дугаар тогтоолоор Арьс, ширний үйлдвэрүүдийн цогцолборыг Дархан-Уул аймагт төвлөрүүлэн байршуулахаар шийдвэрлэж, тус цогцолборын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулахад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 800.0 сая төгрөгийг зарцуулахаар боллоо.	30
4	72.Хангайн бүсийн аймгуудад өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй, говь хээрийн бүсэд өндөр ашиг шимт хонь, ямааны аж ахуйг дэмжих, тариалангийн бүс	5	5.Тариалангийн бүс нутаг дахь эрчимжсэн аж ахуйн тоо, бүтээмжийг нэмэгдүүлнэ.	2013-2016	Эрчимжсэн аж ахуйн тоо, бүтээмж нэмэгдсэн байна.	Аймгийн хэмжээнд газар тариалан эрхэлж буй Хонгор сумын нутагт “Өсөх сүрэг” саалийн үнээний фермер үйл ажиллагаагаа явуулж цаашдаа сүү цагаан идээ боловсруулах цех байгуулан өргөтгөх бодлого баримтлан ажиллаж байна. ЖДҮХСангийн зээлд махны чиглэлийн эрчимжсэн аж ахуйн чиглэлээр боловсруулсан 5 төсөлд 140.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ. ҮХААЯ-наас зарласан “Сүүний үхрийн цогцолбор аж ахуйд дэмжлэг	50

	нутагт дэмшилтэт технологи бүхий фермерийн аж ахуйг хөгжүүлэх					үзүүлэх” төслөөс “Ветмон” ХХКомпанид 10.0 сая, шувууны аж ахуй эрхлэгч “Их мориг” ХХК, “Өгөөж заяа” ХХКомпаниуд “Шувууны аж ахуйд дэмжлэг үзүүлэх” төслөөс 30 сая, “Эрдэнэт зөгий” хоршоо 10 сая, “Сүүний үхрийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх” төслөөс “Улаан зам” ХХК 150 сая, “Ган хос эрдэнэ” ХХК 80 сая төгрөгийн дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөтгөөд байна.	
		6	6.Цогцолбор аж ахуйг түшиглэн малын тэжээлийн үйлдвэр, цех шинээр барьж байгуулна.	2013-2016	Тэжээлийн үйлдвэр, цех байгуулагдсан байна.	Аймгийн ЖДҮХСангийн төслийн сонгон шалгаруулалтад “Баялаг тэжээл” ХХК-ны “Малын багсармал тэжээл”, иргэн Ш.Чинбаатарын “Тэжээлийн үйлдвэр” төслүүд шалгарч дэмжигдсэн байна. Аймгийн хэмжээгээр 5 гурилын үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж малын тэжээл багсармал, хивэг үйлдвэрлэн орон нутгийн малчдыг хангахын зэрэгцээ Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Орхон аймгуудад тэжээлийг борлуулж байна.	30
5	73.Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, зах зээлд нийлүүлэх зорилго бүхий ХАА-н биржийг байгуулах.	7	1.Нийслэл болон аймаг, сумдад хөдөө аж ахуйн биржийн сүлжээ байгуулна.	2013-2016	Биржүүд байгуулагдсан байна.	Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, зах зээлд нийлүүлэх зорилтын хүрээнд “Хан хөхий” ХХК-д Дархан сумын 3-р багт мал нядалгаа түүхий эдийн цэг байгуулах 1 га газрыг олгож энэ онд барилгын ажлаа эхлүүлэхээр төлөвлөөд байна. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж буй мал аж ахуйн түүхий эд эрхлэгчдийн судалгааг нарийвчлан гаргаад байна. “Бурхант таван эрдэнэ” хөдөө аж ахуйн биржийн брокерийн үйл ажиллагааг явуулж байгаа боловч биржийн арилжаанд оролцоогүй байна.	50
6	76.Газар тариалан, фермерийн бүс нутгийг түшиглэн хуурай сүү боловсруулах үйлдвэр, аймгуудад цөцгийн тос болон сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахыг дэмжих	8	2.Баруун болон төвийн бүсийн аймгуудад хоногт 1 тонноос доошгүй сүү боловсруулах хүчин чадалтай үйлдвэр байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.	2013-2014	Үйлдвэр байгуулагдсан байна.	Поликом ХХК-тай сүүний үхэр бүхий малчид, фермерүүдийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсны үр дүнд “Дархан, Сэлэнгийн сүүний үхэр үржүүлэгчдийн холбоо” ТББ байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэллээ. Хүнсний томоохон үйлдвэр Дархан хүнс ХХК, Поликом ХХК нь хоногт 3-аас доошгүй тонны хүчин чадалтай сүүний үйлдвэр байгуулах төсөл боловсруулж, хөрөнгө оруулалтаа шийдэхээр ажиллаж байна. ҮХААЯамны “Сүүний үхрийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх” төсөлд хамрагдан Хонгор сумын “Улаан зам” ХХК 150 сая, Дархан сумын “Ган хос эрдэнэ” ХХК 80 сая төгрөгийн дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөтгөлөө.	30
7	77.Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилгоор	9	1.Мал нядалгааны үйлдвэр, цехэд 3-7 дугаар сард мал нийлүүлсэн малчдад	2013-2015	Өвөл, хаврын улиралд нийлүүлж	Хэрэгжих хугацаа болоогүй.	

	махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлэх.		урамшуулал олгоно.		буй махны хэмжээ өссөн байна.	Хэрэгжилт-.....%	
		10	3.Биржээр малын худалдаа зохион байгуулах ажлыг сум бүрт туршилтын журмаар зохион байгуулна.	2014-2015	Нийт малын 10-30 хувийг биржээр борлуулсан байна.	Малчдын санаачлагаар Орхон суманд нутгийн малын үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулах зорилгоор 12 толгой үүлдрийн бух худалдан авч малчдад нийлүүлээд байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс 25 сая төгрөг зарцуулсан байна. Аймгийн хэмжээнд 9 дүгээр сард зохион байгуулдаг “Намрын ногоон өдрүүд ” үзэсгэлэн худалдаанд “Шилмэл мал”-ын үзэсгэлэн болон дуудлага худалдааг биржтэй хамтран зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	10
8	78.”Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, мал эмнэлэг, үржлийн төрийн үйлчилгээний албыг бүх суманд бэхжүүлэх.	11	1.Мал аж ахуйн үйлдвэрлэлд бүртгэл мэдэллийн нэгдсэн системийг бий болгож, мал, түүний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулдаг болно.	2012-2016	Гарал үүслийг баталгаажуулдаг болсон байна.	“Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2014 оны 5 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 72,6 мянган толгой мал ээмэгжүүлэн бүртгэлд хамруулахаас 44,0 мянган толгой үхэр, 10,4 мянган толгой бог мал ээмэгжүүлэн бүртгэлд хамруулан баяжилт хийгээд байна. Ээмэгжүүлэлт 77 хувьтай байна. Намар үргэлжлүүлэн хийгдэнэ.	50
		12	2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, зорилтот зах зээлийг хөгжүүлнэ.	2012-2016	Үйлдвэрлэлийн бүтээмж, өрсөлдөх чадвар дээшилсэн байна.	Малын үүлдэр угсааг сайжруулах, нэгж малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн бүтээгдэхүүний чанар, төрлийг олшруулсанаар мал аж ахуйн бүтээгдэхүүнийг зах зээлд гарган эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар малчдын өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх юм. Хонгор сумын “Хонгорын бахархал” хоршоо нь Зулзага, Мухар, Хүйтний голын 30 гаруй малчдаас өдөрт 1 тонн гаруй сүү цуглуулан цөцгийн тос боловсруулан сумын иргэдэд нийлүүлж байна. Цаашид сүү, цагаан идээ боловсруулах ажлаа өргөтгөн шар сүү боловсруулах, сувиллын цагаан идээ үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэхээр ажиллаж байна. Мөн Салхитын “Өсөх сүрэг” фермер нь мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн сүү, цагаан идээ боловсруулан Салхит тосгонд нэрийн барааны дэлгүүр ажиллуулан иргэдэд үйлчилж байна.	50
		13	3. Малын удмын сангийн үндэсний цогцолбор байгуулж, малын генетик нөөцийг хамгаалах, ашиглах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2013-2016	Цогцолбор байгуулсан байна.	2013-2014 оны төсөвт тусгагдсан 12.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр цогцолборын инженерийн иж бүрэн шугам сүлжээ болон 14 барилга объектыг барих гүйцэтгэгчээр шалгарсан “НАБСАН” ХХК-тай хийсэн АГТ-20130724-001/162 тоот гэрээ байгуулсанаар Дархан-Уул аймгийн Хонгор суман дахь цогцолборын эзэмшил газарт 2013 оны 08 дугаар сараас эхлэн бүтээн	30

					байгуулалтыг эхлүүлсэн. 2014 оны 05 сарын байдлаар цогцолборын инженерийн шугам сүлжээний байгууламжийн ажлын явц 98.0 хувьтай, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 60.0 хувьтай байгаа бөгөөд 2014 оны 11 дүгээр сард цогцолборын эхний ээлжийн бүтээн байгуулалтын гэрээт ажлыг бүрэн дуусгаж, улсын комисст хүлээлгэн өгөхөөр бүтээн байгуулалтын ажил явагдаж байна.	
		14	6.Бэлчээр, тэжээл, усан хангамжийг зохистой ашиглах, хамгаалах менежментийн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2012-2016	Малын тэжээл, усан хангамж сайжирсан байна.	30
9	93. Импорт оор оруулдаг хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болж, төмс, хүнсний ногоо, сүү, өндөгний хэрэгцээг дотооддоо хангадаг болох.	15	2.Хот суурингийн орчимд 100,0 мянгаас дээш өндөглөгчтэй тахианы цогцолбор аж ахуй 3, аймгийн төвүүдэд 5,0 мянгаас дээш өндөглөгчтэй эрчимжсэн аж ахуй 8-ыг тус тус шинээр байгуулж, өндөгний хангамжийг нэмэгдүүлнэ.	2013-2015	Хүн амын өндөгний хэрэгцээг дотооддоо хангадаг болсон байна.	50
10	168.Монгол хүний эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах.	16	3.Малаас хүнд дэмжин халдварладаг зарим зооноз бруцеллез, ям, сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна.	2012-2016	Халдварын түвшинг бууруулсан байна.	50

						буурч эрүүл аймаг болох нөхцлийг хангасан байна.	
	17	4.Өвчилсөн, үхсэн болон бусад шаардлагаар устгах мал, малын гаралтай түүхий эдийг зориулалтын төхөөрөмж ашиглан шатаадаг болно.	2013-2014	Хөдөлгөөнт шатаах төхөөрөмж ашигладаг болсон байна.		Хэрэгжих хугацаа болоогүй. Үхсэн мал, амьтны сэг, зэм, түүхий эд бүтээгдэхүүнийг устгах зориулалтын шатаадаг төхөөрөмжтэй болох асуудлыг ҮХААЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Мал эмнэлэг үржлийн газраас нэгдсэн журмаар бүх аймгийг хангахаар ажиллаж байна.	10

-тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр гарч, үр дүн гарсан бол 100 хувь;

-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч санхүү, зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь (80.0-100.0 хүртэл хувь);

-тавьсан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь (60.0-80.0 хүртэл хувь);

-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 50.0 хувь (40.0-60.0 хүртэл хувь);

-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 30.0 хувь (20.0-40.0 хүртэл хувь);

-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувь (0-20.0 хүртэл хувь);

-тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийн хувийг “0” гэж үзнэ.